

“ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖТЭЙ НИЙГМИЙН АЖИЛТНЫ ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГААНД АНХААРАХ АСУУДАЛ”

GENDER SENSITIVE SOCIAL WORKER'S FOCUSING PROBLEMS IN PRACTICE



Г.Батжаргал

*Дотоод хэргийн их сургууль Сургалт, судалгааны
403 дугаар анги Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны
сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн ахлах
багш, хошууч*

Хураангуй: Нийгмийн ажил болон жендерийн асуудал хоорондоо нягт холбоотой. Нийгмийн ажилтнууд нийгмийн аливаа асуудлыг шийдвэрлэхийн төлөө үйлчилгээ үзүүлэхдээ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн алинд нь ч нас, хүйс, үндэс угсаа, арьс өнгө, нийгэм, эдийн засгийн байдал зэрэг шинж чанаруудаас үл хамааран тэгш, ялгаварлан гадуурхалтгүй хандах ёстой байдаг. Жендерийн тэгш бус байдал нь нийгмийн шударга бус байдлын илрэлийг бэхжүүлж улам өөгшүүлж байдаг тул нийгмийн ажилтан жендерийн мэдрэмжтэй үйлчилгээ үзүүлэх арга зүйд зайлшгүй суралцах, ур чадварыг эзэмших нь чухал гэж үзэж байна.

Өнөөгийн байдлаар ядуурал, ажилгүйдэл, эмэгтэйчүүдийн эрх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, мансуурал донтолт, гэмт хэрэг үйлдсэн хоригдолтой ажиллахад чиглэсэн үйлчилгээнүүд нийгмийн ажлын практикийн салшгүй хэсэг болж байна. Үүнээс гадна ахмад настны, залуучуудын, хүүхдийн, өрх толгойлсон эцэг/эхчүүдийн, олон хүүхэдтэй гэр бүлийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хорих ял шийтгүүлсэн хоригдлын асуудалд хүний эрхийн болон жендерийн мэдрэмжтэй нийгмийн ажлын практик үйлчилгээг хүргэх асуудал нэн чухал байна.

Жендерт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт нь гэр бүлийн амьдрал, хүүхдийн хүмүүжил, нийгмийн хөгжилд гүн гүнзгий нөлөөлдөг учраас нийгмийн ажилтнууд үйлчлүүлэгчдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх чадвартай байхын тулд тэгш бус байдлын талаар сайн ойлголттой байх нь нийгмийн шаардлага болж байна. Нийгмийн ажлын үйлчлүүлэгчдийн дунд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, хүчирхийллийн хохирогч болох мөн нийгмийн ажилтнуудын дунд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдал байгааг мэдэх нь мэргэжлийн хүмүүс өөрсдийн үйлчлүүлэгчдэд тулгарч буй асуудлын талаар илүү сайн ойлгох боломжийг олгодог.

Иймд энэхүү өгүүлэлд практик ажиллаж буй нийгмийн ажилтан хувь хүн, гэр бүл, бүлэгтэй ажиллахдаа нийгмийн ажлын үйлчилгээний харилцаа холбоо тогтоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх үе шатанд жендерийн мэдрэмжтэй хандах ойлголтыг өмнө хийгдсэн судалгааны ажлын үр дүн, онолын үзэл баримтлалтай холбон, анхаарах асуудлыг тусгасан авч үзлээ.

Түлхүүр үг: Жендер, нийгмийн ажил, асуудал, нөхцөл байдлын үнэлгээ

Abstract: Social work and gender issues are closely related. When social workers provide services to solve any social problem, they must treat both men and women equally and without discrimination, regardless of characteristics such as age, gender, ethnicity, race, social and economic status. Since gender inequality reinforces and exacerbates the manifestations of social injustice, it is important for social workers to learn and acquire skills in gender-sensitive service delivery methods.

Key words: Gender, social work, issues and situational assessment

ҮНДСЭН ХЭСЭГ

Нийгмийн ажилтан ямар хүрээнд үйл ажиллагаа явуулах нь тухайн салбарын нийгмийн ажлын үйлчилгээний онцлог, үйл ажиллагааны чиглэлээс шалтгаалдаг. Нийгмийн ажлын практик нь нийгмийн ажлын үйлчилгээ явуулах орчин, нийгмийн ажилтны арга барил, хууль эрх зүйн орчин, үзүүлж буй үйлчилгээг бүхэлд нь хамардаг. Нийгмийн ажлын практикийн гол зорилго нь нийгмийн шударга ёсыг хангах, хүний эрхийн болон жендерийн мэдрэмжтэй үйлчилгээ хүргэх, нийгмийн тэгш бус байдлыг бууруулахад чиглэгддэг.

Монгол улс жендерийн үзүүлэлтээр олон улсад: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс нөхөн үржихүйн эрүүл мэнд, улс төрийн төлөөлөл, ажиллах хүчний оролцооны үзүүлэлтэд суурилан гаргадаг Жендерийн тэгш бус байдлын үзүүлэлтээр 2018 оны байдлаар Монгол Улс 189 орноос 71-р байранд, Хүний хөгжлийн үзүүлэлтэд суурилан гаргадаг Жендерийн Хөгжлийн Индексээр 92-р байранд орсон байна. 2020 оны байдлаар Дэлхийн Эдийн Засгийн Форумгаас гаргадаг жендерийн зөрүүтэй байдлын үзүүлэлтээр дэлхийн улс орнууд жендерийн тэгш байдлыг хангахад дунджаар 68.6%-тай байна. Монгол Улс нь 70,6% үзүүлэлтээрээ нийт 153 орны дунд 79 дүгээр байранд орж байна.⁸⁵

АНУ-ын судлаач М.Пэйн нийгмийн ажлын практик нь радикал, шүүмжлэлт, марксист ба феминист онолын хандлага дээр тулгуурлаж байгаа бөгөөд агуулга, үйл ажиллагааны хувьд эдгээр хандлагуудад хоорондоо ижил

⁸⁵ Global Gender Gap Index Report

төстэй зүйл байгааг тэмдэглэжээ. Нийгмийн ажлын практикийн жендерийн тал нь онолын болон арга зүйн хувьд феминист хандлага дээр түлхүү суурилдаг байна. ⁸⁶

Нийгмийн ажлын практикт феминизмийн үзэл суртал, гүн ухаан, онол ихээхэн нөлөөлсөн байдаг. Жендерийн мэдрэмжтэй нийгмийн ажлын практик нь үйлчилгээ шаардлагатай хувь хүн, гэр бүл бүлэг, байгууллага, олон нийт зэрэг нийгмийн бүлэг, үйлчлүүлэгчидтэй харилцах үйл явцад хүмүүнлэг, энэрэнгүй, хүний эрх, жендерийн мэдрэмжтэй, шүүмжлэлт, феминист нийгмийн ажлын зарчим буюу эрх мэдлийн зохистой хуваарилалт, үйл явц болон үр дүнгийн тэгш байдал, тэнцвэрт зарчимд суурилдаг. Үйл явц болон үйлчилгээний тэгш байдал нь шударгаар, албадлагагүй, дарамт шахалтгүйгээр үйлчилгээг хүргэх явдал юм. ⁸⁷ Жишээлбэл, ганц бие ээжид байнгын, сэтгэл ханамжтай ажил олоход туслах нь нийгмийн ажилтны хангалттай үйлчилгээ биш, үүний зэрэгцээ нийгмийн халамж, тэтгэмжид зуучлах, мэргэжил олгох сургалтад хамруулах, хүүхдүүдийг цэцэрлэг болон боловсролын үйлчилгээнд хамруулах, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зэрэг ажлууд шаардлагатай.

НҮБХАС, Үндэсний статистикийн хороотой хамтран зохион байгуулсан Жендерт суурилсан хүчирхийллийн үндэсний хэмжээний судалгааны дүнгээр Монгол эмэгтэйчүүдийн 57.9 хувь нь хүчирхийлэлд өртдөг гэсэн үзүүлэлт гарсан. ⁸⁸ Өөрөөр хэлбэл, таван эмэгтэй тутмын гурав нь амьдралынхаа аль нэг үед нөхөр болон хамтран амьдрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн хохирогч болж байгаа юм. Үүнээс 35 хувь буюу гурван эмэгтэй тутмын нэг нь сүүлийн 12 сарын хугацаанд нөхөр болон хамтран амьдрагчийн үйлдсэн хүчирхийлэлд өртсөн болохыг харуулж байна.

Микро түвшний нийгмийн ажлын үйлчилгээний жендерийн асуудлууд:⁸⁹ Хүмүүс олон янзын шалтгаанаар нийгмийн ажилтанд хандаж тусламж үйлчилгээ авдаг учраас хувь хүн, гэр бүлтэй ажиллахад нийгмийн ажилтнаас жендерийн тухай олон талын мэдлэг, ур чадвартай, мэдрэмжтэй байхыг шаардаж байна. Хувь хүн, гэр бүлийн асуудлыг ойлгож танин мэдэхэд хувь хүний онцлог, бусдаас ялгаатай байдал, зан үйл, ухамсрын түвшин, уламжлал, соёл, шашны онцлогийг судалдаг. Жишээ нь: нэг эмэгтэй олон дүр, үүргийг гүйцэтгэдгээс (ээж, эхнэр, охин, найз, хамтран ажиллагч, зөвлөгч, санаачлагч, зохион байгуулагч гэх мэт) хамааран жендерийн хэвшмэл ойлголт бүрэлдэх эсвэл жендерт суурилсан хүчирхийлэлд өртөх, нийгмийн үзэгдлүүд бий болдог. Иймд

⁸⁶ М.Батбаатар, А.Батхишиг, Ш.Оюунханд, Г.Түмэннаст (2019). Жендерт суурилсан хүчирхийлэл ба нийгмийн ажлын арга зүй сургалтын гарын авлага. Улаанбаатар.

⁸⁷ Т.Амаржаргал, С.Түмэндэлгэр (2008). Жендерийн тэгш эрх хөгжлийн агуулга болох нь. Улаанбаатар.

⁸⁸ “ЖЕНДЭР СУДЛАЛ” эрдэм шинжилгээний сэтгүүл 96 тал

⁸⁹ Т.Бүрэнжаргал, С.Хандмаа нар “Жендер ба нийгмийн ажил” УБ 2021 он

тухайн хүний өсөж төрсөн гэр бүл, нийгэм, соёлын орчин, итгэл үнэмшил, үнэт зүйлийг ойлгох нь чухал юм.

Микро түвшинд үйлчлүүлэгчтэй харилцаа холбоо тогтоохдоо ганцаарчлан уулзах, зайнаас буюу цахим орчноос холбогдох, утсаар холбогдох харилцаа холбоо тогтоох зэрэг хэлбэртэй байна. Мөн үйлчлүүлэгчтэй харилцаа холбоо тогтоох явцад гарах саад бэрхшээл нь үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдал, үйл хөдлөл, аман болон аман бус харилцаа, дохио зангаа үүсэж болох саад бэрхшээлүүд зэргийг авч үздэг. Иймд нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэй хийх анхны уулзалтаас өмнө бэлтгэлийг хангах нь маш чухал. Энэ нь нийгмийн ажилтан өөрийгөө харилцаанд бэлтгэх гэсэн үг юм. Тодруулбал: а) Хувь хүн, гэр бүл, бүлэгт чиглэсэн үр дүнтэй, бодитой үйл ажиллагаанд бэлтгэх ур чадвартай байх, б) Эмпати харилцааны ур чадвартай байх, в) Харилцан ойлголцож, нэгдмэл үр дүнд хүрэхэд чиглүүлэх ур чадвартай байх юм.⁹⁰

Нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ нэг талаас үйлчлүүлэгчийн талаарх ойлголт мэдээллийг хамруулах, нөгөө талаас цаашдын үйл ажиллагаа үйлчилгээнд хэрэгтэй мэдээллийг олж авахад чиглэгдэнэ. Мөн үйлчлүүлэгчийн тулгамдаад байгаа асуудлын мөн чанар, түүнд үзүүлэх үйлчлүүлэгчийн хариу үйлдэл, орчны нөлөө, асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой хувь хүний чадвар, боломж, нөөц эх сурвалжууд зэрэг мэдээллийг цуглуулна. ХНХЯ, ХЗДХЯ-ны сайдын хамтарсан тушаалаар нөхцөл байдлын үнэлгээ хийх журам, гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээний маягт, хүүхэд хамгааллын үйлчилгээний багц маягтуудыг баталснаар нийгмийн ажилтнуудын мэдээлэл цуглуулах, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх боломжтой болсон.⁹¹

Үйлчлүүлэгчийн нөхцөл байдлын үнэлэх явцад жендерийн мэдрэмжтэй хандах: Тухайн хүний өсөж төрсөн нийгэм, соёлын орчныг судлахдаа нийгмийн ажилтнууд жендерийн мэдрэмжтэйгээр гэр бүлийн үнэт зүйл, соёл, уламжлал, гэр бүлийн гишүүдийн харилцаа, үүрэг, түүний хэлбэр, үр дагавруудад дүн шинжилгээ хийх нь шаардлагатай байдаг. Харвардын их сургуулийн хүүхдийн хөгжлийн мэргэжилтэн Burton L.White "Гэр бүлийн хүүхдэд өгөх албан бус боловсрол нь хүүхдийн өгч буй албан боловсролоос илүү хүчтэй нөлөө үзүүлдэг" хэмээсэн бол Р.Воег-ийн үзсэнээр "Гэр бүл бол хичээлийн танхим, харин эцэг эх бол анхны багш" юм. Хүүхдийн бага насанд нь анхны багш болох эцэг эх нь халамж хамгаалал үзүүлж чадахгүйгээр үл барам, үл хайхрах, гэр бүлийн хүчирхийлэл, дарамт дээрэлхэлтэд өртүүлснээр тархины хөгжилд ноцтой өөрчлөлтийг бий болгож, хожим тухай хүний хөгжил, нийгэмд бие хүн болон төлөвшихөд сөрөг үр дагаврыг бий болгодог.

⁹⁰ Т.Цэндсүрэн (2008). Хувь хүн, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил. Улаанбаатар.

⁹¹ Ж.Занаа, О.Оюунцэцэг, Б.Онон, Т.Амгалан (2018). Жендер ба бодлого төлөвлөлт. Улаанбаатар

*Судалгааны дүнгээс харахад гэр бүлийн хүчирхийлэл жендэрт тулгуурлан тэдний биеэ хамгаалах чадваргүй, сул дорой байдлыг ашиглан сүүлийн жилүүдэд өсөж байгааг харж болно. Тухайлбал, 2020 оны эхний 08 сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас 716 иргэн хохирсон, үүнээс 640 буюу 89.4 хувь нь эмэгтэй, 56 буюу 7.8 хувь нь хүүхэд эзэлж байна. Дээрх хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 7394 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1967 буюу 36.2 хувиар, зөрчил гаргасан 5783 хүнийг баривчлах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 616 буюу 11.9 хувиар тус тус өссөн нь жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл ихсэж байгааг харуулж байна.*⁹²

Статистикаас харвал эрчүүд хүчирхийлэгч болж эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөгч болсон үзүүлэлт байна. Энэ бол жендерийн тэгш байдал алдагдсаны илрэл юм. Үүнд жендерийн тэгш эрх яригддаг, эрэгтэй эмэгтэй хүмүүс бие биенээ хүндэтгэж, тэгш харьцдаг байсан бол гэр бүлийн хүчирхийлэл гарахгүй, гэр бүл цуцлалтын тоо бага байх боломжтой.

Үүнээс харахад үйлчлүүлэгчийн асуудлыг танин мэдэхэд жендерийн харилцаа (харилцаа, хэрэгцээ шаардлага, эрх мэдэл, үүргийн хуваарилалт, хэм хэмжээ)-г анхаарах нь чухал юм. Нийгмийн ажлын үйлчилгээ авч буй хүний мөн чанар, хэрэгцээ шаардлага, хүлээлт нь харилцан адилгүй байдаг учраас нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн асуудалд жендерийн мэдрэмжтэй хандах нь нийгмийн ажлын ёс зүйн дүрэмтэй нийцэж байдаг.

Гэр бүл нийгэмд болон хувь хүнд маш олон үүрэг гүйцэтгэдэг. Гэр бүл нийгмийн өмнө хүлээсэн үүргээ хэр зэрэг биелүүлэхээс нийгмийн ирээдүйн төлөв байдал ихээхэн шалтгаална. Гэр бүл нийгмийн институт болохын хувьд материаллаг баялгийг үйлдвэрлэх хуваарилахад оролцож байдаг. Гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай гишүүд нийгмийн үйлдвэрлэлд идэвхтэй оролцож боловсрол мэргэжлээ дээшлүүлэн овсгоо самбаатай байж материаллаг нөхцөл байдлаа дээшлүүлэх боломжтой болно. Нөгөө талаар нийгмийн үүрэг хариуцлагын тэнцвэрт байдал алдагдаж байна. Үндэсний статистикийн хорооны нээлттэй мэдээллийн сангаас ажиллах хүчний оролцоон дахь жендерийн ялгааг тодорхойлоход ажиллах хүчний оролцооны түвшинг авч үзвэл эрэгтэйчүүд 70.7% байхад эмэгтэйчүүд 5.9% байна.⁹³ Үүний гол шалтгаан нь эмэгтэйчүүд суралцах болон хүүхэд асрах үүргийг түлхүү хүлээсэнтэй холбоотой.

Гэр бүлийн хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм, сэтгэл зүйн онцлог, ялгаатай байдлыг хүндэтгэх:

Гэр бүл дэх эрэгтэй, эмэгтэйчүүдийн хүйсийн эрх мэдлийн тэгш бус харилцаа, хөдөлмөрийн хуваарь нь гэр бүлийн гишүүдийн байр суурь, эрүүл мэнд,

⁹² Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 2020 оны 3 сарын 23 өдөр шинэчлэгдсэн.
www.1212.mn

⁹³ www.1212.mn

боловсролын ялгаатай байдлыг үүсгэж, улмаар жендерт суурилсан хүчирхийлэл гарч болзошгүй юм.

Гэр бүл төлөвлөлтийг эрэгтэй эмэгтэйчүүдийн асуудлаас гадна нийгэм соёл, улс төрийн бодлоготой холбон тайлбарладаг учраас жендерийн мэдрэмжтэй байх. Жишээ нь, эмэгтэйчүүд сүүлийн 3-5 жил тасралтгүй нийгмийн даатгал төлөөд эхний төрөлтөд амаржсаны тэтгэмжээ бүрэн авах, хоёр дахь төрөлтөд цалингийн доод хэмжээгээр 4 сар авах, харин тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тасралтгүй төлж чадаагүй эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсдэггүй. Энэ нь гэр бүл төлөвлөлт болон гэр бүлийн эдийн засгийн асуудал, эмэгтэйчүүдийн сэтгэл зүйн хямралд өртөх эрсдэл өндөр байдаг.⁹⁴

Мөн гэр бүлийн дотор жендерийн тэгш бус байдлыг батжуулдаг гол хүчин зүйл нь гэрийн болон нийгмийн хөдөлмөрийн ялгаа зааг юм, чухамдаа эмэгтэйчүүд халамжлагчид болж, эрэгтэйчүүд нь эдийн засгийн талаас ханган нийлүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг. Хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, хүүхэд арчлах үнэ хөлсгүй ажлын ачаалал нь эмэгтэйчүүд дээр буудаг. Түүгээр ч зогсохгүй эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх асуудлыг голчлон цалин хөлстэй ажлын талбарт орох боломж, оролцооны хүрээнд ойлгодог ба тэдний цалин хөлсгүй гүйцэтгэж байдаг ажил үүргийг бараг анхааралдаа авахгүй байх хандлага байна.

- Гэр бүлд чиглэсэн тусламж үйлчилгээний хүртээмж, чанар, амьдрах орчин болон өрхийн бусад гишүүдийн хандлага, оролцоог судлах, мэдээлэл зөвлөгөө өгөх
- Үйлчлүүлэгч өөрийн амьдралтай холбоотой аливаа шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл өгөх, жендерийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтыг танин мэдэх
- Үйлчлүүлэгчийг нийгэмшүүлэх, нийгмийн амьдралд оролцох оролцоог сайжруулахад хүний эрхийн болон жендерийн тэгш байдлыг хангах

Боловсролын салбарт жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааг дэмжих. Үүнд: Багш нар эрэгтэй, эмэгтэй хүүхдийн ялгаатай байдал болон тэдэнд хандах хандлагыг өөрчлөх,

Хөвгүүдийн дуулгаваргүй, дүрсгүй, биеэ даасан байдал, зан үйлийг хүлээн зөвшөөрдөг бол охидын хувьд дуулгаваргүй байх, бие даасан байдлыг сөрөг үг хэллэгээр хэлэх, доромжлох эсвэл эсрэгээр огт анхаарал хандуулахгүй байгааг анхаарч багш, сурагч, эцэг эх гэсэн гурвалсан дэмжих үйлчилгээг үзүүлэх,

⁹⁴ М.Батбаатар, А.Батхишиг, Ш.Оюунханд, Г.Түмэннаст (2019). Жендерт суурилсан хүчирхийлэл ба нийгмийн ажлын арга зүй сургалтын гарын авлага. Улаанбаатар.

Жендерийн мэдрэмжид нийцсэн анги танхимын зохион байгуулалт, онцлог хэрэгцээг бүрдүүлэх (ангид охид хөвгүүд холимог байх, ангийн үйл ажиллагаа болон сургалт, уралдаан тэмцээнд тэгш хамруулах, хүний эрх болон жендерийн эрх тэгш байдлын талаар үзүүлэх, ханын самбар, үйл ажиллагаа зохион байгуулах)⁹⁵

Гэр бүлийн хүчирхийллийг гэр бүлийн дотоод асуудал гэж үзэх хандлага манай улсад түгээмэл байсан хэдий ч сүүлийн жилүүдэд батлагдан гарсан бодлого, хуулийн дагуу энэ нь хүний эрхийн зөрчил төдийгүй зарим үйлдлийг нь зөрчил, гэмт хэрэг гэж үздэг болсон. Иймд гэр бүлийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, эсвэл гэр бүл, ойр дотны харилцаатай хүмүүс хоорондоо шийдэх асуудал гэсэн нэрийдлээр хүчирхийлэлд өртсөн, хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүнийг хамгаалахгүйгээр, үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэх боломжийг багасгаж байна. Нөгөө талаар хувь хүний эрхэм чанар, эрх чөлөөг нь хүлээн зөвшөөрч, хүндэтгэхийн зэрэгцээ тэдний аюулгүй, хараат бус, халдашгүй амьдрах эрхийг тэргүүн зэрэгт үзэж хэрэгцээнд нь мэдрэмжтэй хандсан үйлчилгээг шуурхай хүргэх шаардлагатай. Хуулийн байгууллагын ажилтнууд, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэгчид бүгд хүний эрхийн хамгаалагчид юм.

Бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын жендерийн асуудал⁹⁶ Нийгмийн ажилтнууд бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхдээ хүмүүсийн нийгмийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бүлгээр дамжуулан нийгэм дэх хувь хүн, бүлгийг асуудлаа илүү үр дүнтэй шийдвэрлэхэд тусалж, онцгой хэрэгцээ шаардлагыг жендерийн мэдрэмжтэйгээр харгалзан үзсэнээр илүү бодит үр дүнд хүрч болно.

Бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын хүрээнд хувь хүн, бүлгийн зорилго, үнэт зүйлийг тодорхойлох, тэдний нөхцөл байдлыг үнэлэх, хүмүүсийн хоорондын харилцаа, туслалцаа үзүүлэх арга хэлбэрийг тодорхойлоход жендерийн мэдрэмжтэй арга зүй ёсоор шаардагдана. Бүлэгтэй ажиллахад хүмүүсийн зан үйл болон хувь хүний хөгжлийн харилцаа, харилцааны чадвар, хүмүүсийн хөгжүүлэх, чадавхжуулах, нөхөн сэргээх, зохион байгуулах өвөрмөц онцлог, хэрэгцээг үйлчилгээнүүд байдаг.⁹⁷

Эрүүл мэндийн салбарт тулгарч буй нэг асуудал бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тэдний чөлөөтэй зорчих, нэвтрэх дэд бүтэц бүхий зам харилцаа байхгүй, ерөнхий боловсрол болон их дээд сургуульд сурч боловсрох нөхцөл хангалтгүй, нийгэм, олон нийтийн зүгээс үзүүлэх ялгаварлан гадуурхалт их зэрэг нь жендерийн мэдрэмжгүй

⁹⁵ Мартин Маргер. Нийгмийн тэгш бус байдал. Загвар ба үйл явц, Mc Mc Mgraw Hill (2001)

⁹⁶ Т.Бүрэнжаргал, С.Хандмаа нар “Жендер ба нийгмийн ажил” УБ 2021 он

⁹⁷ Т.Цэндсүрэн (2008). Хувь хүн, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил. Улаанбаатар.

бодлогын нэг хэлбэр болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ахмад настан, эмэгтэйчүүдийн нийгмийн амьдралд оролцох оролцоо маш хязгаарлагдмал байдаг. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон эрүүл мэндийн боловсрол авах эрхийг үл ойшоосон нөхцөл байдал үүсэхэд хүргэж байна. Эдгээр иргэдийн асуудлыг ажил мэргэжлийн хүрээнд судлах, жендерийн тэгш байдлыг ханган ажиллах нь нийгмийн ажилтнуудын нэг чухал үүрэг юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настны бүлэгт тулгамдаж буй жендерийн ялгаварлан гадуурхалтад өртөж буй дараах асуудлууд байна. Үүнд:

- Хүүхэд эрүүл аюулгүй орчинд өсөж, хөгжих боломж нөхцөл бүрдээгүй
- Эцэг эхийн гэр бүлийн доторх үүрэг хариуцлага, хүүхдээ харж хандах, дэмжих, анхаарал сул төдийгүй, үл хайхрах, бэлгийн болон бүх хэлбэрийн хүчирхийлэлд өртөх
- Бусдаас ялгаатай байдлаас хүүхэд өөртөө итгэлгүй байх, нийгмээс өөрийгөө улам ихээр тусгаарлах
- Сургууль, цэцэрлэгийн орчинд найз нөхөд, багш, алба хаагчдын ялгаварлан гадуурхалт, харилцааны тааламжгүй байдал
- Хүүхдийн эрүүл мэнд, зан үйлд нийгэм, олон нийт, хэвлэл мэдээлэл, цахим орчны мэдээлэл, сурталчилгаа нөлөөлөх
- Сэтгэцийн ямар нэг хэлбэрийн хөнгөнөөс хүнд хэлбэрийн асуудалтай байх
- Осол гэмтэлд өртөх, удаан хугацаанд өвдөх нь бэрхшээлийг улам хүнд хэлбэрийнх болгох
- Хүүхдүүдийн дарамт дээрэлхэлтийг бууруулах арга хэмжээ дутмаг, хууль эрх зүйн орчин бүрэлдээгүй
- Сургууль, хүүхдийн байгууллагууд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаанд хяналт, хамтын ажиллагааны туршлага солилцох нь дутмаг, хариуцлага тодорхой бус
- Жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчид нийгэм, олон нийтийн үйл ажиллагаанд оролцохгүй ганцаардмал байх, бусдаас өөрийгөө хязгаарлах, ялгаварлан гадуурхагдах гэх мэт асуудлуудын суурь шалтгаан нь жендерийн мэдрэмжтэй үйлчилгээ үзүүлэх нь чухал байна. ⁹⁸

⁹⁸ Мартин Маргер. Нийгмийн тэгш бус байдал. Загвар ба үйл явц. Mc Mc McGraw Hill (2001),

ДҮГНЭЛТ

Нийгмийн ажлын практикт жендерийн тэгш бус байдлыг илрүүлэх, жендерийн мэдрэмжтэй нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх асуудлыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Жендерийн тэгш байдлыг бий болгохын тулд бодит байдалд дүн шинжилгээ хийх нь практик нийгмийн ажилтнуудад зөвхөн тодорхой нэг нөхцөл байдал эрэгтэй, эмэгтэй хүмүүст ийм байдлаар нөлөөлж байна гэдгийг гаргаж ирэх бус, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах явдал жендерийн тэгш байдлыг тогтоох нь чухал юм. Нийгмийн ажилтнууд жендерийн тэгш бус байдлыг хувь хүн, үйлчлүүлэгч, гэр бүл, бүлэг олон нийтийн түвшинд үйлчилгээ үзүүлэхдээ хүлээн зөвшөөрч жендерийн мэдрэмжтэй ажиллах нь нийгмийн ажлын ёс зүйн суурь зарчим, хэм хэмжээтэй нийцэж байдаг учраас ялгаварлан гадуурхалтгүй нийгмийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн шударга ёсыг тогтооход нөлөөлдөг.

Хувь хүнтэй ажиллах нийгмийн ажил, харилцаа холбоо тогтоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх үе шатад жендерийн мэдрэмжтэй хандах: Нийгмийн ажлын үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчдийн дийлэнх нь зорилтот бүлгийнхэн (ганц бие ахмадууд, өрх толгойлсон эхчүүд, олон хүүхэдтэй эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, хорих ял шийтгүүлсэн хоригдол, ЛГБТ хүн, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, мансууруулах бодис, цахим тоглоомд донтогчид, ажилгүйчүүд) байдаг. Тэд гэр бүлийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, ялгаварлан гадуурхалт, жендерт суурилсан хүчирхийлэл, жендерийн тэгш бус байдалд байнга өртөж, нийгмийн хөгжлийн үр шимээс орхигдсоор байна.

Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээнд практик нийгмийн ажилтан жендерийн мэдрэмжтэй хандах: Манай улсад хэрэгжиж буй Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид хүчирхийлэл дарамтаас урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэхэд нийгмийн ажилтнуудын үүргийг тусгасан байна.

Бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээнд жендерийн мэдрэмжтэй хандах: Өсвөр насны хүүхдүүд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд эмэгтэйчүүд, хүчирхийлэл үйлдэгч эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ЛГБТ үйлчлүүлэгч зэрэг асуудал бэрхшээлээ тээж яваа хүмүүст дэмжлэг туслалцаа үзүүлэхэд жендерийн мэдрэмжтэй байх тэдний эрхэм чанарыг хүндэтгэх нь хандлагатай мэргэжилтэн байх шаардлагаас үүдэлтэй байна.

САНАЛ

Нийгмийн ажилтан мэргэжлээр суралцаж буй оюутнуудад хувьд жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн, ажлын байрны зэрэг бүхий л хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон хүчирхийллийн хохирогч, даван туулагчдад шаардлагатай нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг үзүүлэх

чиглэлээр өндөр мэдлэг, хандлага, ур чадварыг эзэмшсэн байхад анхаарч жендерийн агуулга бүхий бие даасан хичээлийг орж, жендерийн тухай мэдлэг, хандлагатай мэргэжилтэн бэлтгэх,

Практик нийгмийн ажилтнууд жендерийн мэдрэмжтэй үйлчилгээ үзүүлэх арга зүйгээр хангах, ур чадварыг эзэмшүүлэх зорилгоор мэргэшүүлэх сургалтыг хөтөлбөр, төлөвлөгөөтэй явуулдаг байх,

Нийгмийн салбарын тулгамдсан асуудал болж буй жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, тэднийг нийгэм, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээхэд олон талт оролцоо хүчин чармайлт шаардлагатайг хүлээн зөвшөөрч нийгмийн ажил, сэтгэл судлал, хууль зүйн туслалцаа үзүүлэх, нийгмийн халамжийн зэрэг салбар дундын хамтын ажиллагаа, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Гэр бүлийн хүрээнд эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүдтэй адил тэгш хамтрагч байж оролцуулах талаар зохих хууль, дүрэм боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага байсаар байна. тухайлбал гэр бүлийн тэгш эрх, эдийн засгийн шударга ёсыг дэмжин дэлгэрүүлэх үүрэгтэй хөдөлмөрийн хуулийн хүрээнд хэрэгжүүлэх ёстой. Үүнд тэгш бөгөөд шударга хөдөлмөрийн хөлс, тэгш бөгөөд ажлын баталгаатай тэгш цалин хөлстэй амралт, сайжруулсан ажлын нөхцөл, ажлын байрны сургалт, нийцтэй ажил зэргийг зохицуулсан бодлоготой байх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Т.Бүрэнжаргал (2017). Нийгмийн ажлын мэргэжлийн ёс зүй. Улаанбаатар.
- Т.Бүрэнжаргал, С.Хандмаа нар “Жендер ба нийгмийн ажил” УБ 2021 он
- Т.Цэндсүрэн (2008). Хувь хүн, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил. Улаанбаатар.
- М.Батбаатар, А.Батхишиг, Ш.Оюунханд, Г.Түмэннаст (2019). Жендерт суурилсан хүчирхийлэл ба нийгмийн ажлын арга зүй сургалтын гарын авлага. Улаанбаатар.
- Ж.Занаа, О.Оюунцэцэг, Б.Онон, Т.Амгалан (2018). Жендер ба бодлого төлөвлөлт. Улаанбаатар
- Т.Амаржаргал, С.Түмэндэлгэр (2008). Жендерийн тэгш эрх хөгжлийн агуулга болох нь. Улаанбаатар
- Мартин Маргер. Нийгмийн тэгш бус байдал. Загвар ба үйл явц. Mc Mc Mgraw Hill (2001),
- www.social worker.org/practice/ adolescent health/ah0102.asp
www.12